



# “ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

№ .....1.....

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Женко тур бюро”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Женко тур бюро” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 сарын 29-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Соёлын ордны хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - a. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - b. 2018 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
  - c. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
  - d. Компанийн нэрийг өөрчлөх
  - e. Дүрмийн өөрчлөлтийг батлах
  - f. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
  - g. Хөрөнгө оруулалт санхүүжилтийн төлөвлөгөө
  - h. ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 19 дэх өдөр буюу 2019 оны 04 сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээллэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2019 оны 03 сарын 20-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2019 оны 04 сарын 04-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.
7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай .
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2019 оны 04 сарын 29-ний 10:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.

Чингис Хааны өргөн чөлөө, Ш Х-43, Баянгол Оффис 1 давхарт, Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 976-7012-0202 Факс: 976-11321705

И-Шуудан: info@genco-tour.mn www.genco-tour.mn

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Д.Даянбилгүүн, хурал зохион байгуулах комиссийн даргаар Баярцэцэг гишүүнээр Д.Шүрэнцэцэг, Отгонбаяр Хажидсүрэн, тооллогын комиссын даргаар Батцэрэн, гишүүнээр Энхбаяр, Лхагважав нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Д.ДАЯНБИЛГҮҮН /